



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/9

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалт болон “Таванбогд капитал ҮЦК” ХХК-ийн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний 43/А-15 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн “Таванбогд капитал ҮЦК” ХХК-ийн ажилтан Н.Мөнхчимэгийн /ZGB.CH/ арилжаанд оролцох эрхийг хааж, тус компанийн ажилтан М.Нямдэмбэрэлд, Гүйцэтгэх захирал Г.Мөнх-Эрдэнийн /ZGB.ME/ арилжаанд оролцох эрхийг хааж, тус компанийн ажилтан З.Отгонзаяа нарт үнэт цаасны арилжаанд оролцох эрхүүдийг тус тус олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1522020019